БАТЛАВ.
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЖАРГАЛСАЙХАН

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хугацаа | Хариуцан хэрэгжүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжит хэлбэрээр албан хаагчид болон олон нийтэд сурталчилж байх; | - Баримтжуулсан байх<br>- Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) | Жилийн турш | Бүх тасаг |
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах; | -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | Жилийн турш | Ёс зүйн зөвлөл<br>Сургалт сурталчилгааны мэргэжилтэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон нийт албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх; | -Шинэ томилогдсон болон нийт албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Жилийн турш | Ёс зүйн зөвлөл, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн |
| 3 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1. Хэлтсийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах; | - Байгууллагын албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээнд тухай бүр байршуулсайн байх | Жилийн турш | Санхүү бүртгэлийн тасаг, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн |
| 4 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 4.1. Нийгмийн даатгалын үйлчилгээ авч байгаа иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах чиглэлээр зурагт хуудас түгээх; | -Зурагт хуудас хэвлүүлж, түгээсэн байх | Жилийн турш | Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн |
| | | 4.2. Нийгмийн даатгалын салбарт хийгдсэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудас, facebook, болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр түгээх ажлыг зохион байгуулах; | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байх | Жилийн турш | Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн |
| | | 4.3. Дотоод нөөц бололцоог ашиглан албан хаагчдад сургалт зохион байгуулсан байх; | - Албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх;<br>- Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Улирал бүр | Бүх тасаг, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн |

oOo

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
## 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД | | | |
| 1 | 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжит хэлбэрээр албан хаагчид болон олон нийтэд сурталчилж байх; | - Баримтжуулсан байх<br>- Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) | 1. Авлигатай тэмцэх газрын АТГ-Олон Нийтийн Төв цахим хуудсанд тавигдсан шторк, постерыг өөрийн байгууллагын мэдээллийн самбар, https://songinohairhan.ndaatgal.mn/ болон *facebook.com/Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын газар* цахим хуудсаар дамжуулан байршуулж, олон нийтэд түгээж байна.<br>Газрын ажилтан, албан хаагчдыг өөрийн цахим хуудсаараа дамжуулан бусдад түгээн олон нийтэд сурталчлахыг төрийн албан хаагчийн хувьд үүрэг болгосон бөгөөд нийтдээ 6 шторк, постерийг 7 удаагийн түгээлтээр 77 шэйр хийсэн.<br>2. Албан хаагчдын дотоод цахим сүлжээнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас 5 удаа мэдээлэл хүргэж ажиллалаа. |
| | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах; | -2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх;<br>-Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх. | 1. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газраас Авлигатай тэмцэх газартай хамтран "Бид-Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон" аяныг нэг сарын хугацаанд хэрэгжүүлсэн. Аяны хүрээнд ажилтан, албан хаагчдыг авлигаас ангид байлгах, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Б.Сүрэнжав 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр тус газрын 30 албан хаагчдад сургалт мэдээлэл хүргэлээ. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 2. Авлигын эсрэг нэгдэж *facebook.com/Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын газар* цахим хуудсаар дамжуулан 3 постер байршуулж, 2 удаагийн түгээлтээр 64 шэйр хийгдсэн байна. |
| АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРГАЛТАД ХАМРУУЛАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД | | | |
| 2 | 2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон нийт албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх; | -Шинэ томилогдсон болон нийт албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | Шинээр томилогдсон албан хаагчийг хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ёс зүйн хэм хэмжээг чандлан, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үүссэн зөрчлийн шалтгаан нөхцлийг тодорхойлох, тэдгээрийг арилгах, таслан зогсоох, иргэд, олон нийтийг зөвлөгөө мэдээллээр хангах зорилго бүхий төрийн албанд анх томилогдон ажиллаж буй албан хаагчдад зориулсан"ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ" сэдэвт сургалтыг зохион байгуулах хүсэлтийг Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ийн гаргасны дагуу тус газрын шинээр томилогдсон 10 албан хаагч уг сургалтад хамрагдлаа. Сургалтыг Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ийн Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д. Амарбаясгалан удирдан явууллаа. /2024.08.30/ |
| АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ БИЙ БОЛГОХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД | | | |
| 3 | 3.1. Хэлтсийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах; | - Байгууллагын албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээнд тухай бүр байршуулсайн байх | 1.*https://auth.itc.gov.mn/,* https://songinohairhan.ndaatgal.mn/ *facebook.com/Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс* зэрэг цахим хуудсаар байгууллагын үйл ажиллагааны 11 төрлийн, нийгмийн даатгалын сангийн 12 төрлийн орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг байршуулж хэвшлээ.<br>2. *https://auth.itc.gov.mn/* -д байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 171 төрлийг мэдээлэлийг тухай бүр хугацаанд байршуулж ажиллаж байна. Хяналт шалгалтын улсын байцаагч нар "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг хяналт шалгалт хийх бүртээ гаргаж хэвшсэн. |
| БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ, САНААЧИЛГА ӨРНҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД | | | |
| 4 | 4.1. Нийгмийн даатгалын үйлчилгээ авч байгаа иргэдийн мэдээлэл авах | -Зурагт хуудас хэвлүүлж, түгээсэн байх | Байгууллагын давхар бүрт байрлах мэдээллийн самбарт иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор нийгмийн даатгалын тухай гарын авлага, брошур тогтмол байршуулж хэвшсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| | эрхийг хангах чиглэлээр зурагт хуудас түгээх; | | |
| | 4.2. Нийгмийн даатгалын салбарт хийгдсэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газрын цахим хуудас, facebook, болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр түгээх ажлыг зохион байгуулах; | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байх | 1.Нийгмийн даатгалын ерөнхий газраас бэлтгэсэн Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх бэлтгэсэн 8 төрлийн постерийг *facebook.com/Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын газар* цахим хуудсаар 8 удаагийн түгээлтээр 138 шэйр хийсэн.<br>2.Байгууллагын 2 давхрын "Мэдээллийн самбар"-т Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудаас тус тус ээлжлэн байршуулж хэвшлээ. Мөн газрын албан хаагчдын албан хаагчдын фэйсбүүк дотоод группт 8 удаагийн мэдээллийг байршуулж, таниулах ажлыг зохион байгуулж байна. |
| | 4.3. Дотоод нөөц бололцоог ашиглан албан хаагчиддаа сургалт зохион байгуулсан байх; | - Албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх;<br>-Тайланд нотломжийг хавсаргасан байх. | 1."Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр комиссар Р.Төрбулаг, "Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт" сэдвээр комиссар М.Жамъяачойжил нар цахимаар (Zoom )сургалт зохион байгуулав. 2024.10.18-ний өдөр сургалтад 19 албан хаагч оролцов.<br>2.Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2024 оны 11 дүгээр сарыг **"Ёс-той Зүй-тэй"** нөлөөлийн аян өрнүүлэхээр тогтсон. Аяны зорилго нь Төрийн албанд ёс зүйн тухай хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх, зөрчлийг мэдээллэх, нийгэм дэх эерэг, зөв хандлагыг дэмжих зорилготой юм. Энэхүү аянд нэгдэж, тус газрын Ёс зүйн дэд хорооноос сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтыг "Ёс зүйн академи"-ийн ерөнхийлөгч, Олон улсын хуульч (Ph.D) Ж.Оймандах "Байгууллагын ёс зүйн менежмент" сэдвээр удирдан явуулж, тус газрын албан хаагчид хамрагдав.<br>2024.11.14-ний өдөр сургалтад оролцогчийн тоо 48<br>3."Дотоод Луужин"сэтгэлзүйн сургалтын төвийн Сэтгэлзүйч О.Тэгшжаргалын "Өөрийгөө хайрлая" сэдэвт сургалтанд хамрагдлаа. Хувь хүний сэтгэлзүйн онцлог, ажлын байрны стресс, |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ажлаас халшрах хам шинж, өөрийгөө хайрлах гээд олон төрлийн мэдлэг мэдээллээр хангасан үр дүнтэй сургалт болж өндөрлөлөө. 2024.11.22-ны өдөр сургалтад оролцогчийн тоо 43 |

---oOo---

## *НОТЛОМЖ*

Арга хэмжээ 1.1.1









Арга хэмжээ 1.1.2















Арга хэмжээ 1.2.1





Арга хэмжээ 1.2.2






Арга хэмжээ 2.1.1





Арга хэмжээ 3.1.1












Арга хэмжээ 4.1.1








Арга хэмжээ 4.2.1















Арга хэмжээ 4.2.2






Арга хэмжээ 4.3.1






Арга хэмжээ 4.3.3







---oOo---